

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бадамдаш	Дугаар	L084
Оршин суугаа аймаг	Хэнтий аймаг	Оршин суугаа сум	Улаанбаатар хот
Төрсөн газар	Батширээт сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ламын хүрээ	Сүм хийдийн дугаар	ХЭБР 086
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

### Хэнтий аймгийн Биндэр сумын Өлзийхутаг Ном Аривдах сүм ба Ламын хүрээ

Баруунтай Балданбэрээвэн хийд гэж, энэ зүүнтэй Угтамын хийд гэж бий. Энэ 2 том хийд байсан. Дорнод аймгийн Угтамын хийд Дорнод аймгийн Баяндун, Дашбалбар сумын зааг нутагт байдаг. Хошуу бүр хошууны хийдтэй байсан. Тэр бол хошуу захиргаандаа тайлангаа тавидаг. Шанзудбын яамны харъяа хоёр том хийд нь тэр яаманд тайлан тооцоогоо хийдэг. Манай энэ Цэцэн хаан аймгийн Жонон вангийн хошуу гэж аймгийн дайтай хамгийн том сүм байсан. Хамгийн том, гол хийд нь Балданбэрээвэн хийд байлаа. Дараа нь орохоор хийд бол Өлзийхутаг Ном Бадрах сүм гэж шашны нэртэй олон түмэндээ Ламын хүрээ гэж алдаршсан хошуу хийд энд байсан. Биндэр суманд орж байгаа. Их хурлын үеэр Балданбэрээвэн хийдэд 3000 лам нар, энэ Ламын хүрээний их хуралд 900-1000 лам нар цуглаж хурдаг байсан. Надад хотод Балданбэрээвэн, Ламын хүрээний хамба лам нарын нэрсийн жагсаалт бий. Хөгшин бид хоёр бол хотын хүн. Улаанбаатарт нэг их удаагүй. Тавиадхан жил болсон. Энд ирж зусдаг. Майдарын Пүрэвдорж гэж нам төрийн ажил хийж явсан хүний хоёр ном бий. Хөвчийн Жонон вангийн хошууны түүхэн тэмдэглэл гэдэг ном, Балданбэрээвэн хийдийн товч түүх гэж хоёр ном бий. Тэр номуудыг уншсан байхад Пүрэвдоржоос илүү үг хэлэх хүн одоо байхгүй. Харин худлаа хэлье гэвэл болох байх. Одооны энэ сурвалжлагчид шиг. Манай нутгийн нэг хүн Мянгат малчдын хуралд сая хотод очоод ирсэн. Тэгсэн нэг сурвалжлагч ирээд ярилцлага авч. Радиогоор нэр устай нь Хэнтий аймгийн Батширээт сумын 5000 малчин Чой гээд л залж өгч байгаа юм.

Шүтээн дов бол Социализмын үед модны рамны дов болоод. Сүүлийн хиртэй бол согтуугийн дов болоод. Одоо ганц хоёр айл байгаа байх. Түүнээс одоо суурь энэ тэр байхгүй.

Ашингыг дуганыг нааш нь авч ирээд юу гэдэг нэртэй билээ дуган болгоод Батширээт сумын төв дээр авчраад байгаа. Лам байхгүй. Бархын ловон бол нэг айл суусан дов байгаа. өөр юу ч байхгүй.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Биндэр суманд бол Өлзийхутаг ном Дэлгэрэх сүм гэдэг сахилын нэртэй олон түмэнд Ламын хүрээ гэж алдаршсан хийд байсан. Одоо үүний дурсгал болгож нутгийн хоёр бүриад дархан хүүхдүүд сайхан модон дуган босгосон. Одоо дуганы сахиул л байгаа байх. Лам байхгүй. Цаашаа яваад Баян-Адаргад харин ганц хоёр ламтай байх. Би тэгж тааж байна. Биндэр, Батширээт хоёр бол ламгүй болчихоод байгаа. Цаашаа Дадал орно. Дадалд ямар хийд байсан юм мэдэхгүй. Сэрүүн дуганыг сэргээсэн. Манай нутгийн дүүчин бүдүүн хоолоотой Пүрэвдорж сая өөд болсон, зохиолч Сэнгийн Эрдэнэ, Данзангийн Гүрдорж гэж манайхны нэг багш хүн байсан. Энэ гурван хүн санаачлан сэргээсэн. Бас л лам байхгүй. За тэгээд миний мэдэх юм ийм л байх шив дээ.

-Танаас асуух нэг юм байна. Хурх голын хойно, Дэчинчойлон хийд гэж байсан байна. Батширээгээс баруун урагшаа чигтэй Өмнөдэлгэртэй залгаа газарт байгаа?

Би энэ талаар сонсоогүй юм байна. Өмнөдэлгэр гэдэг чинь буруу нэр юм шүү дээ. Балданбэрээвэн хийдийн чинь хойд талаар нь байгааг Хойд Их Дэлгэр гэдэг. Урд талаар байгааг нь Өмнөдэлгэр уул гээд Өмнөдэлгэр сум гээд нэрлэчинсэн. Тэгэхлээр зэрэг хуучин Мэргэн гүний хошуунд харъяалагдаж байсан хэдэн үхэр халхчууд их баян, малтай тэд Хэнтий сумыг нийлүүлэхэд Өмнөдэлгэр сум гээд Хойд Дэлгэрийг нь хаячихсан. Хоёр Дэлгэр сум гэх нь яасан юм. Ерөөсөө тэгэхгүй Хэнтий сум гэж нэрлэж ч болох л байсан юм шүү дээ.